

# НЭГ. ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН СТРАТЕГИ



**Алсын хараа:** Тогтвортой хөгжлийг хангах усны үйлчилгээг ухаалаг, уян хатан зохицуулагч манлайлах байгууллага байна.

**Уриа:** Ус – бидний одоо ба ирээдүй

**Эрхэм зорилго:** Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхүйц, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй усны үйлчилгээг үр өгөөжтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

## ХОЁР. МАНДАТ

### Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн МАНДАТ

- Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг тогтоох
- Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- Мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах;
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ.

### Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдогч талууд



## ГУРАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай, явуулах нөхцөлийг бүрдүүлэн, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй үйлчилгээг хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

## **ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА**

*Тогтвортой хөгжлийг хангах усны үйлчилгээг ухаалаг, уян хатан зохицуулагч манлайлах байгууллага байна.*

Бидний уриа: *Ус – бидний одоо ба ирээдүй*

## **ТАВ. ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛС, ЗАРЧИМ**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг биелүүлэх, өөрийн мандатыг хэрэгжүүлэхдээ дор дурдсан эрхэмлэх зүйлсийг баримтална.

**Баталгаатай** – Усны үйлчилгээг тасралтгүй, аюулгүй, найдвартай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;

**Тэгш, хүртээмжтэй** - Усны үйлчилгээг хэрэглэгч-хүн бүр боломжийн үнээр, тэгш хүртэх боломжтой байх;

**Үр ашигтай** – Усны зүй зохистой хэрэглээг дэмжих, өрсөлдөөнт зах зээлийг бий болгох, үнэ тарифыг оновчтой тогтоох;

**Байгаль орчинд ээлтэй** – Усны алдагдлыг бууруулах, хэмнэлттэй, чанарыг сайжруулах, бохирдлыг цэвэрлэн дахин ашиглах боломжийг хангах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник, технологи ашиглахыг дэмжих;

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлж, эрхэмлэх зүйлсээ дээдлэн, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үндэс суурь нь дор дурдсан үйл ажиллагааны зарчмууд байна. Үүнд:

**Хууль дээдлэх** – Үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, тогтоомжийг хэлбэртэлгүй сахин биелүүлэх, хэрэглэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах;

**Хараат бус байх** - Иргэн, хуулийн этгээдээс хараат бус байж, аливаа нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

**Хариуцлагатай, ил тод байх** – Үйл ажиллагаагаа ил тод явуулж, хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалж, аливаа асуудлыг цаг хугацаанд нь үр дүнтэй шийдвэрлэх;

**Хэрэглэгчийг дээдлэх** – Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дээдлэх;

**Мэргэшсэн байх** – Мандатаар хүлээсэн ажил үүргээ мэргэжлийн өндөр түшинд, үнэнч шударгаар, ёс зүй, ёс суртахууны зарчмыг баримтлан гүйцэтгэх;

**Шинийг эрэлхийлэгч, манлайлагч байх** – салбарын зорилгод хүрэхэд шаардлагатай зорилтуудыг дэвшүүлж, санаачлага гарган бусдыг уриалж, эрсдлийг үнэлэн шийдвэр гаргах, зохицуулалтын шинэ арга барилыг үйл ажиллагаандаа тасралтгүй нэвтрүүлэх.

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019-2022 стратегийн төлөвлөгөөний хүрээнд дараах таван үндсэн стратегийн зорилгыг дэвшүүлж байна. Үүнд:


- Стратегийн зорилго №1.** Усны үйлчилгээг хэрэглэгчид шударгаар, тэгш хүртэх боломжийг хангах;
- Стратегийн зорилго №2.** Усны үйлчилгээний давамгай байдалд үр дүнг чухалчилсан зохицуулалт хийх;
- Стратегийн зорилго №3.** Хангагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;
- Стратегийн зорилго №4.** Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- Стратегийн зорилго №5.** Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох

**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн стратегийн зорилгуудын харилцан уялдаа:**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн мандатад тулгуурласан стратегийн таван зорилго нь тус зөвлөлийн эрхэм зорилгыг хэрэгжүүлж, алсын хараанд хүрэхэд чиглэгдэх юм.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн стратегийн таван зорилго нь өөр хоорондоо нягт уялдаатай хэрэгжинэ. Энэ уялдааг зураг 1-д үзүүлэв.

Зураг1.



## ДОЛОО. ХСУХАТАУЗЗ-ийн СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛХАМУУД

### Стратегийн 1 дүгээр зорилго: Усны үйлчилгээг хэрэглэгчид шударгаар, тэгш хүртэх боломжийг дээшлүүлэх;

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр хорооллын хэрэглэгчдийн усны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр хорооллын УТБ-иудыг ухаалаг болгох ажлыг зохион байгуулах;</li> <li>• Сумдын УХАТ-ыг сайжруулах зохицуулалтыг хэрэгжүүлэх;</li> <li>• Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах, эко 00 нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээгээр хангагдах нөхцөл сайжирна. 50-иас дээш хувь нь 24 цаг усаар хангагдана</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчид усны үйлчилгээг тэгш хүртэх боломжийг дээшлүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчийн төлбөрийн чадварт судалгаа хийж, “амьжиргаа тэтгэх” усны хэмжээг тодорхойлох, төлбөрийн тогтолцоог нэвтрүүлэх;</li> <li>• Усны нөөцийн хүрэлцээтэй уялдуулан хэрэглээнээс хамаарсан шаталсан тариф хэрэгжүүлэх,</li> <li>• Урьдчилсан төлбөрийн тогтолцоог нэвтрүүлэх;</li> <li>• Тоолууржилтыг нэмэгдүүлж, хэрэглэсэн хэмжээгээр төлөх нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>• Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтэд тулгуурласан эргэх холбоот системийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх;</li> <li>• Хаягдал бохир усны төлбөрийг бохирдлын түвшинтэй нь уялдуулсан, суурь тарифтай төлбөрийн тогтолцоог хөгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эмзэг бүлгийн хэрэглэгчид усаар тэгш хангагдана.</li> <li>• Хэрэглээнээс хамаарсан төлбөрийн тогтолцоо боловсронгуй болно.</li> <li>• Тоолууржилтыг 90%-д хүргэнэ.</li> <li>• Хэрэглэгчдийн усны үйлчилгээ нээс хүртэх сэтгэл ханамж өснө. Бохирдуулсан нь төлнө.</li> </ul>
<b>Дотоод үйл ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Усны үйлчилгээний төлбөрийн тогтолцоог боловсронгуй болгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол хүний онцлогт тохирсон “амьжиргаа тэтгэх” усны хэмжээг тогтоох судалгаа хийх;</li> <li>• Хэрэглэгчийн төлбөрийн чадварын үнэлгээг, хэрэглэгчийн ангиллаар тогтоох судалгаа хийх;</li> <li>• Цэвэр, бохир усны үйлчилгээний аргачлалыг улам боловсронгуй болгоно;</li> <li>• Хангагч, хэрэглэгчийн эрх үүрэгт нийцсэн усны үйлчилгээний төлбөрийн журам боловсруулж хэрэгжүүлэх;</li> <li>• Лаг, бохир ус тээврийн жишиг тарифыг боловсруулах;</li> <li>• Ухаалаг хэрэглээг дэмжих, тоолууржилтыг нэмэгдүүлэх заавар, зөвлөгөө боловсруулах;</li> <li>• Гэр хорооллын УТБ-ыг ухаалаг болгох, заавар зөвлөгөө боловсруулах, хугацаатай зорилтуудыг ТЗЭ-дэд өгөх,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Усны үйлчилгээний тарифын тогтолцоо боловсронгуй болно.</li> <li>• Хэрэглэгчийн тоолууржилт нэмэгдэнэ.</li> <li>• Ухаалаг ус түгээх байрны тоо нэмэгдсэнээр салбарын зардал буурна.</li> </ul>

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Санхүү</b>	<ul style="list-style-type: none"> <li>Судалгааны төслийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэглэгчийн төлбөрийн чадвар, “амьжиргаа тэтгэх” усны хэмжээг тогтоох судалгаануудад шаардлагатай хөрөнгийн тооцоо хийж, холбогдох төслийн эх үүсвэрүүдэд суулган, ажлын даалгавар боловсруулах, хэрэгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“амьжиргаа тэтгэх” тарифтай болно.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Ухаалаг УТБ-ын төсөв, үр ашгийн судалгаа хийж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төсвийн тооцоог хийж, БХБЯ, БХТ болон хэрэгжиж байгаа төслүүдэд хүргүүлэх, хэрэгжүүлэхэд зохицуулалтын бодлогоор дэмжлэг үзүүлэх, Салбарын стратегийн бодлогод суулгах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гэр хорооллын иргэдийг 24 цаг усаар хангах асуудал салбарын стратегид тусч хэрэгжүүлэх төлөвлөгөө гарна</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Тоолууржилтыг нэмэгдүүлэх хөрөнгийн судалгааг хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тоолууржилтыг нэмэгдүүлэх судалгааг хийх БХБЯ, БХТ болон хэрэгжиж байгаа төслүүдэд хүргүүлэх, хэрэгжүүлэхэд зохицуулалтын бодлогоор дэмжлэг үзүүлэх, Салбарын стратегийн бодлогод суулгах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тоолууржилтыг нэмэгдүүлэх асуудал салбарын стратегид тусч, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарна</li> </ul>
<b>Сургалт хөгжил</b>	<ul style="list-style-type: none"> <li>“Амьжиргаа тэтгэх” хэмжээ, тариф тооцох аргачлалыг эзэмшүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ажилтнуудын мэдлэг чадварын судалгааг хийж, сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тарифын тооцоо судалгаа алдаагүй хийгддэг болно.</li> </ul>

### Стратегийн 2 дугаар зорилго: Усны үйлчилгээний давамгайл байдалд үр дүнг чухалчилсан зохицуулалт хийх

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч</b>	<ul style="list-style-type: none"> <li>Усны үйлчилгээний салбарт бодит өртөг, хөрөнгийн зардал болон ашгийн зохих түвшинг хангасан үнэ тарифын тогтолцоог хөгжүүлэх;</li> <li>Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны үйлчилгээний үнэ тарифын өнөөгийн байдалд үнэлгээ хийж, тарифын бодлогыг оновчтой болгох;</li> <li>Тарифыг индексжүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;</li> <li>ТЗЭ-дийн өртөг, зардалд шинжилгээ хийж, зардлын жишиг боловсруулан харьцуулалт хийх, зардал бууруулах урамшуулын тогтолцоог нэвтрүүлэх;</li> <li>Зардал хянах зорилгоор усны үйлчилгээнд төлбөрт үйлчилгээний жишиг тариф, тогтоох;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын санхүүгийн тогтвортой байдал хангагдана.</li> <li>Хэрэглэгчид төлбөрт үйлчилгээний сонголт хийх, харьцуулах боломж бүрдэнэ.</li> <li>Салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэнэ.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Салбарт зах зээлийн өрсөлдөөний тэнцвэрт нөхцөлийг бүрдүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны үйлчилгээний зохицуулалттай зах зээлийн зарчим, дүрэм, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх;</li> <li>ТЗЭ-дийн өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;</li> <li>Усны үйлчилгээний зах зээлийн загварт нийцүүлэн ТЗЭ-дэд тавигдах нөхцөл шаардлагыг боловсронгуй болгох;</li> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэглэгчид усны үйлчилгээгээр найдвартай хангагдах нөхцөл дээшилнэ.</li> <li>Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон үйл ажиллагаа нь зах зээлийн загварт суурилсан байна</li> </ul>

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
	<ul style="list-style-type: none"> <li>Төвлөрсөн бус усны үйлчилгээний зах зээлийг зохицуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төвлөрсөн бус УХАТ-ын одоогийн байдлыг судлах, шаардлагатай үйл ажиллагаа, зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох, авч хэрэгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төвлөрсөн бус УХАТ-ын хэрэглэгчдийн үйлчилгээгээр хангагдах нөхцөл дээшилнэ.</li> </ul>
<b>Дотоод үйл ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>Усны үйлчилгээний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах дүрэм, журамтай болгох;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Усны үйлчилгээний салбар зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах боломжийг судлах;</li> <li>Салбарын зах зээлийн загварууд, олон улсын хөгжлийн чиг хандлагын судалгаа хийх;</li> <li>Усны үйлчилгээний салбарын нөхцөлд тохирсон зах зээлийн загварыг судалгааны үндсэн боловсруулж, хэрэгжүүлэх боломжийг судлах;</li> <li>Салбарын зах зээлд оролцогч талуудын үйл ажиллагааны зарчим, дүрэм, журмыг боловсруулж хэрэгжүүлэх;</li> </ul>	<p>УХАТ-ын салбар зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцөл бүрдэнэ.</p>
	<ul style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>УХАТ-ын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэх;</li> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнд суурилсан зохицуулалтын механизмыг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗЭ-дийн чадавх дээшилнэ.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн цахим санг хөгжүүлж, ашиглах, ил тод нээлттэй байдлыг хангах;</li> <li>ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагааг уялдуулан тооцдог аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, хэрэглэгчийн итгэл хүлээнэ</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Бороо, хөрсний усны төлбөрийн тогтолцоог хөгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бороо, хөрсний усыг төвлөрсөн шугамд нийлүүлэхэд төлбөр тооцдог гадаад орны жишгийг судлах;</li> <li>Төвлөрсөн шугамд нийлүүлж байгаа бороо, хөрсний ус зайлуулах, төлбөр тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орлого болоогүй бохир усны хэмжээ буурна.</li> </ul>
<b>Санхүү</b>	<ul style="list-style-type: none"> <li>Нөөцийг үр дүнтэй ашиглах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нөөц (санхүү, хүний нөөц, материаллаг) үр дүнтэй хуваарилж, зарцуулах жишиг загвар боловсруулах;</li> <li>Хөрөнгө оруулалтыг татах цэвэр бохир усны үйлчилгээний бодит өртгийг тодорхойлж, тарифын шинэчлэлтийг үе шаттай хэрэгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ТЗЭ-ийн санхүүгийн байдал бэхжинэ.</li> <li>Салбарын санхүү бүртгэлийн үйл ажиллагаа нэгдсэн бодлогын дагуу явагддаг болно.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Салбарт санхүү бүртгэлийн нэгдсэн бодлоготой болох;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх;</li> </ul>	

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Сургалт хөгжил</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үр дүнд суурилсан зохицуулалт хийх мэдлэг чадвар эзэмшүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаадын бусад улс орнуудын зохицуулалтын аргыг судлаж, өөрийн орны нөхцөлд хэрэгжүүлэх боломжийг тодорхойлж, нэвтрүүлэх;</li> <li>• Үр дүнд суурилсан зохицуулалтыг хийх менежментийн арга барилыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зохицуулалт хийх арга барил шинэчлэгдэнэ.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Зах зээлийн болон өртөг зардлын судалгаа хийх, тариф индексжүүлэх арга зүйг ажилтнуудад эзэмшүүлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны арга барилыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах;</li> <li>• Гадаад орны зохицуулах байгууллагуудын туршлага судлах;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Индексжүүлэлтийн тооцоо, зах зээлийн судалгаа, өртгийн судалгаа алдаагүй зөв хийгддэг болно.</li> </ul>

### Стратегийн 3 дугаар зорилго: Хангагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээний чанар стандартыг дээдэлсэн хариуцлагын тогтолцоог хангагч байгууллагуудад нэвтрүүлэх</li> <li>• Эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан эргэх холбоог хангагч байгууллагын үйл ажиллагааг сайжруулах арга, механизм болгож хэрэгжүүлэх</li> <li>• Эрсдэлд суурилсан усан хангамжийн дүрэм журмын биелэлтэнд хяналт, шалгалт явуулах</li> <li>• Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулах, арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчдийн хээ хэрэгцээ шаардлагад тулгуурласан хариуцлагын тогтолцоо нэвтэрнэ.</li> <li>• хяналт, шалгалтын үйл явц ил тод, шударга хийгддэг болно</li> </ul>
<b>Дотоод үйл ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хууль, тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалт хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх</li> <li>• Хяналт, шалгалтын үр дүнг тооцох аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хяналт, шалгалтыг явуулах журам, аргачлал, стандарт боловсруулах, холбогдох ажлуудыг зохион байгуулах.</li> <li>• ТЗЭ-ийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээнд анализ хийх, ангилах, ангиллыг шинэчлэн тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх.</li> <li>• Хяналт, шалгалтын төлөвлөгөөг эрсдлээс хамааруулан боловсруулж, хэрэгжүүлэх.</li> <li>• Эрсдлийн түвшингээс нь хамааруулан тохирсон хяналт шалгалтыг хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалтыг зохион байгуулах</li> </ul>	<p>Салбарын зохицуулалтын үйл ажиллагаа нь ТЗЭ-ийн бодит байдалд тулгуурлана.</p> <p>Хяналт, шалгалттай холбоотой нөөц /цаг хугацаа, хүний нөөц, өртөг, зардал/-ийн хуваарилалт, зарцуулалт оновчтой болно.</p>
<b>Санхүү</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг бүрдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагаатай холбоотой зардлыг төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих</li> </ul>	<p>Хяналт шалгалт төлөвлөсөн хугацаанд саадгүй, үр дүнтэй хэрэгждэг болно</p>



<b>Сургалт хөгжил</b>	Албан хаагчдыг хяналт, шалгалтыг зохион байгуулах аргачлалаар хангах, ажлын гүйцэтгэлийг сайжруулах.	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээний чанар, стандарт болон эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хийхэд шаардлагатай мэдлэг, чадварыг албан хаагчдад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах</li> </ul>	Хяналт, шалгалтын ажлын үр дүн сайжрана.
-----------------------	--	--	--

**Стратегийн 4 дүгээр зорилго: Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх**

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч</b>	<ul style="list-style-type: none"> <li>• УХАТ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх</li> <li>•</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сумдын УХАТ-ын байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах</li> <li>• Ундны усны эх үүсвэрийн харуул хамгаалалтыг сайжруулах</li> <li>• Зөөврийн усан хангамжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэх</li> <li>• Сайжруулсан АЦБ-ын тоог нэмэгдүүлэх</li> <li>• Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх</li> <li>• Бага дунд оврын АЦБ-ын туршилт тохируулгыг жигдрүүлэх, байгальд нийлүүлж байгаа бохир усны стандартыг сайжруулах</li> <li>• ТХЗ-ын хангагдсан хүн амын судалгааг гаргах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутаг, сумдын эх үүсвэрийн аюулгүй байдал сайжирна.</li> <li>• Зөөврийн усан хангамжийн үйлчилгээ сайжирна.</li> <li>• Баталгаат ундны ус, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоо өснө.</li> </ul>
<b>Дотоод үйл ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой хөгжлийн зорилтын хангахад чиглэгдсэн зохицуулалтын орчинг бүрдүүлэх, судалгаа явуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ТХЗ-ыг хангуулах чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх,</li> <li>• төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх</li> <li>• Зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох</li> <li>• Мэдээллийн санг байгуулах</li> <li>• Уур амьсгалын өөрчлөлтэй уялдуулан гадаргын усыг ашиглах судалгааг явуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад дотоод хамтын ажиллагаа сайжирна</li> <li>• Зохицуулалтын таатай орчин бүрдэнэ</li> </ul>
<b>Санхүү</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Зорилтыг хангах зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх судалгааны төсвийг бүрдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрдэм шинжилгээ, судалгааны төсвийг боловсруулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх байгууллагуудтай хамтран ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц бүрдэнэ</li> </ul>
<b>Сургалт хөгжил</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажиллагсдын тогтвортой хөгжлийн зорилтыг хэмжих, судалгаа хийх мэдлэг, ур чадвар, хандлага, ажлын гүйцэтгэлийг сайжруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой хөгжлийн зорилтыг хэмжих, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Салбарын хэмжээнд боловсон хүчний чадавхи бэхжинэ</li> </ul>

## Стратегийн 5 дугаар зорилго: Чадварлаг, мэргэшсэн, манлайлагч байгууллага болох

Ерөнхий чиглэл	Зорилт	Үйл ажиллагаа	Дунд хугацааны хүрэх үр дүн
<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч</b>	Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэй хангасан бодлого, зохицуулалтыг боловсруулж, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих	<ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг тогтмолжуулж хэрэгжүүлэх.</li> <li>• Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг цаг үеэ олсон, хүртээмжтэй мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.</li> <li>• Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэй хангасан бодлого, зохицуулалтыг боловсруулж, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих</li> </ul>	Байгууллагын үйл ажиллагаа нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагын итгэлийг хүлээнэ
<b>Дотоод үйл ажиллагаа</b>	Зохицуулах Зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хангуулах, Салбарт инновацийг манлайлан хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Усны үйлчилгээний салбарын хөгжлийн чиг хандлага, шинэлэг зүйлсийн талаар судалгаа, шинжилгээг тогтмол хийх</li> <li>• Салбарыг хөгжлийг дэмжсэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх</li> <li>• Олон улсын туршлагаас судалж өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх</li> <li>• Усны үйлчилгээний чиглэлийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх</li> <li>• Олон улсын усны зохицуулалтын байгууллагууд мэргэжлийн холбоодтой хамтарсан идэвхитэй үйл ажиллагаа, хэргийн түншлэл бий болгох</li> </ul>	<p>Эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын үнэт зүйл бүхий соёл төлөвшинө.</p> <p>Улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын салбарын хөгжлийг манлайлагч байгууллага болно</p>
<b>Санхүү</b>	Санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн үйл ажиллагааг холбогдогч талуудад шуурхай, тогтмол мэдээлдэг болох</li> <li>• Санхүүгийн бүртгэл, тооцоог стандартын дагуу хэрэгжүүлж хэвшүүлэх</li> </ul>	Байгууллагын санхүүгийн чадавхи бэхжиж, санхүүгийн тогтвортой байдал хангагдана
<b>Сургалт хөгжил</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөлийн хүний нөөцийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллах нөхцлийг хангах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөлийн хүний нөөцийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх</li> <li>• Мэдлэг чадварт суурилсан хүний нөөцийн сонгон шалгаруулалтын тогтолцоог нэвтрүүлэх.</li> <li>• Хүний нөөцийн сургалт, хөгжлийн хэрэгцээнд суурилсан хэрэгцээнд суурилсан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх</li> </ul>	Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, хүний нөөцийн ажлын гүйцэтгэл сайжирна

# НАЙМ. ХСУХАТАҮЗЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зураг 2.Бүтэц, зохион байгуулалтын зураглал



## ЭРХ ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ, ЗАХИРГААНЫ АЛБА

Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба нь стратегийн таван зорилгын хэрэгжилтийн уялдаа холбоог хангаж “Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох” гэсэн стратегийн 5 дугаар зорилгод чиглүүлэн Зөвлөлийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагыг хангахад гол үүрэгтэй ажиллана. Дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Зохицуулах зөвлөлийн өдөр тутмын, хэвийн үйл ажиллагааг хангуулах
- Зохицуулах зөвлөлийн дарга, гишүүдийг шаардлагатай мэдээ, судалгаагаар хангах
- Зохицуулах зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах, хянах
- Зохицуулах зөвлөлийн ажлын албаны хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх
- Зохицуулах зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх

## ҮНЭ ТАРИФЫН АЛБА

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын алба нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 3 дугаар бүлгийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол улсын усны үйлчилгээний тарифын тогтолцоог шинэчлэн, үнэ тарифын талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих;
- Усны үйлчилгээний үнэ тариф тооцох аргачлал боловсруулах, батлуулах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны шаардагдах зардал(БОш) болон үйлчилгээний тарифыг хянах, судалгаа тооцоог Зохицуулах зөвлөлийн хуралд танилцуулж батлуулах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн дүгнэх, судалгаа хийх;
- Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагын санхүү-эдийн засгийн материалыг хянах, дүгнэлт гаргах, Зохицуулах зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын санхүү эдийн засгийн үзүүлэлтүүдээр мэдээллийн сан бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд усны үйлчилгээний салбарын хэмжээний үзүүлэлтээр олон нийтэд болон холбогдох байгууллагад мэдээлэл бэлтгэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үнэ тарифтай холбоотой мэдээлэл, өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;

### **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛБА**


Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Тусгай зөвшөөрлийн алба нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах, хүчингүй болгох
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийн хянах
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, эд хөрөнгөө барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх
- Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах, нэгтгэх
- Аж ахуйн харилцааны дүрэм батлах
- Техникийн нөхцөл олгох журам батлах
- Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой өргөдлийн маягт, нөхцөл шаардлага боловсруулах, Зохицуулах зөвлөлөөр батлуулж, мөрдүүлэх
- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх

## ЕС. ХСУХАТАҮЗЗ-ийн БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН УЯЛДАА

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь 2019-2022 онд хэрэгжүүлэх стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэхдээ тус зөвлөлийн нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог дараах байдлаар хангаж ажиллана.

Зураг 3. Бүтэц, зохион байгуулалт ба Стратегийн зорилгуудын харилцан уялдаа



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь бүтэц, зохион байгуулалтын хувьд нэгж тус бүр өөрсдийн үндсэн үүргээс гадна Зөвлөлийн үндсэн зорилго, нэгж хорооны уялдаа холбоо, нэгдсэн байдлыг хангах туслах үүргийг мөн гүйцэтгэнэ. Тухайлбал, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн стратегийн зорилгын биелэлтийг хангахын тулд тус Зөвлөлийн нэгж тус бүр өөрсдийн үндсэн үүргийн хүрээнд **зорилгын манлайлагч буюу лидер**<sup>1</sup> болж ажиллана.

Стратегийн зорилгыг манлайлагч нэгжүүд нь үйл ажиллагааны хувьд харилцан уялдаатай ажиллах нь дээрх таван стратегийн зорилгын биелэлтийг хангах гол үндэс болно. Мөн Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн стратегийн зорилгын хүрээнд тус Зөвлөлийн нэгжүүд нь

<sup>1</sup> **Зорилгын лидер** нь стратегийн тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд манлайлах үүрэгтэй оролцоно. Зохицуулах зөвлөлийн нэгж бүр тодорхой нэг стратегийн зорилгыг өөрийн чиг үүргийн дагуу хариуцан ажиллахын зэрэгцээ, тухайн зорилгыг хэрэгжүүлэхэд бусад нэгж, ажилтнуудыг татан оролцуулах, хамтын шийдэл гаргах, үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад манлайлан ажиллана.

өөрсдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийн зорилготойгоо уялдуулан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна.

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дор дурдсан хамтын ажиллагааны хэлбэрийг ашиглах нь зүйтэй юм. Үүнд:

1. **Төслийн ажил:** Тогтоосон хугацаанд, төлөвлөсөн нөөцийг ашиглан, тодорхой үр дүнд хүрэхэд чиглэгдсэн дэд төслүүдийг боловсруулж стратегийн төлөвлөгөөний зарим үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Төслийн баг нь Зөвлөлийн ажилтнууд болон мэргэшсэн зөвлөхүүдээс бүрдэж болно. Стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим үйл ажиллагаанууд нь тодорхой нэг төслийн хүрээнд багц ажил болон хэрэгжих боломжтой.,
2. **Багаар ажиллах:** Стратегийн зорилтыг хангах үйл ажиллагаа бүтцийн нэгж дангаараа хариуцан хэрэгжүүлэхээс илүүтэйгээр мэргэшсэн, мэдлэг чадвартай ажилтнуудын оролцоог хангасан багийн зохион байгуулалтад тулгуурлах нь оновчтой юм.
3. **Өдөр тутмын ажил:** Бүтцийн нэгжүүд нь чиг үүргийнхээ дагуу стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг шууд хариуцан хэрэгжүүлнэ.

Зураг 4.



## АРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Стратегийн 1 дүгээр зорилго: Усны үйлчилгээг хэрэглэгчид шударгаар, тэгш хүртэх боломжийг дээшлүүлэх**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
1.1	Гэр хорооллын УТБ-уудыг ухаалаг болгох ажлыг зохион байгуулах;	ТЗА, ЭЗМЗА	2019-2022	Төслөөр болон багаар
1.2	Сумдын УХАТ-ыг сайжруулах зохицуулалтыг хэрэгжүүлэх;	ТЗА, ЭЗМЗА, ҮТА	2019-2022	Төслөөр болон багаар
1.3	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах, эко 00 нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	ТЗА, ЭЗМЗА	2019-2022	Төслөөр болон багаар
1.4	Хэрэглэгчийн төлбөрийн чадварт судалгаа хийж, “амьжиргаа тэтгэх” усны хэмжээг тодорхойлох, төлбөрийн тогтолцоог нэвтрүүлэх;	ҮТА	2019-2021	Багаар ажиллах
1.5	Усны нөөцийн хүрэлцээтэй уялдуулан хэрэглээнээс хамаарсан шаталсан тариф хэрэгжүүлэх,	ҮТА, ТЗА	2020-2022	Багаар ажиллах
1.6	Урьдчилсан төлбөрийн тогтолцоог нэвтрүүлэх;	ҮТА	2020-2022	Багаар ажиллах
1.7.	Тоолууржилтыг нэмэгдүүлж хэрэглээнийхээ хэрээр төлөх нөхцөлийг бүрдүүлэх; заавар, зөвлөгөө боловсруулах	ҮТА, ЭЗМЗА, ТЗА	2019-2022	Багаар ажиллах
1.8	Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, хүсэлтэд тулгаарласан эргэх холбоо бүхий үйл ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлж хэрэгжүүлэх.	ЭЗМЗА, ТЗЭ, ҮТА	2019-2022	Багаар ажиллах
1.9	Хаягдал бохир усны төлбөрийг бохирдлын түвшинтэй нь уялдуулсан, суурь тарифтай төлбөрийн тогтолцоог хөгжүүлэх	ҮТА, ТЗА	2019-2022	Багаар ажиллах
1.10	Монгол хүний онцлогт тохирсон “амьжиргаа тэтгэх” усны хэмжээг тогтоох судалгаа хийх;	ҮТА, ЭЗМЗА	2019-2020	Төслөөр
1.11	Хэрэглэгчийн төлбөрийн чадварын үнэлгээг, хэрэглэгчийн ангиллаар тогтоох судалгаа хийх;	ҮТА, ЭЗМЗА	2019-2020	Төслөөр
1.12	Хангагч, хэрэглэгчийн эрх үүрэгт нийцсэн усны үйлчилгээний төлбөрийн журам боловсруулж хэрэгжүүлэх;	ҮТА, ЭЗМЗА	2020-2021	Багаар ажиллах
1.13	Лаг, бохир ус тээврийн жишиг тарифыг боловсруулах;	ҮТА, ТЗА	2019-2020	Төслөөр
1.14	Хэрэглэгчийн төлбөрийн чадвар, “амьжиргаа тэтгэх” усны хэмжээг тогтоох судалгааг явуулах;	ҮТА	2019-2020	Багаар ажиллах

**Стратегийн 2 дугаар зорилго: Усны үйлчилгээний давамгайл байдалд үр дүнг чухалчилсан зохицуулалт хийх**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
2.1	Усны үйлчилгээний үнэ тарифын өнөөгийн байдалд үнэлгээ хийж, тарифын бодлогыг оновчтой болгох;	ҮТА	2019-2020	Багаар ажиллах
2.2	Тарифыг индексжүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;	ҮТА	2020-2022	Багаар ажиллах
2.3	ТЗЭ-дийн өртөг, зардалд шинжилгээ хийж, зардлын жишиг боловсруулан харьцуулалт хийх, зардал бууруулах урамшуулын тогтолцоог нэвтрүүлэх;	ҮТА	2019-2021	Багаар ажиллах
2.4	Зардал хянах зорилгоор усны үйлчилгээнд төлбөрт үйлчилгээний жишиг тариф, тогтоох;	ҮТА, ТЗА	2019-2020	Багаар ажиллах
2.5	Усны үйлчилгээний зохицуулалттай зах зээлийн зарчим, дүрэм, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх;	ҮТА, ЭЗМЗА	2019-2022	Багаар ажиллах
2.6	ТЗЭ-дийн өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;	ҮТА, ТЗА, ЭЗМЗА	2019-2021	Багаар ажиллах
2.7	Усны үйлчилгээний зах зээлийн загварт нийцүүлэн ТЗЭ-дэд тавигдах нөхцөл шаардлагыг боловсронгуй болгох;	ТЗА, ҮТА, ЭЗМЗА	2019-2022	Багаар ажиллах
2.8	ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
2.9	Төвлөрсөн бус УХАТ-ын одоогийн байдлыг судлах, шаардлагатай үйл ажиллагаа, зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох, авч хэрэгжүүлэх;	ТЗА, ҮТА	2019-2022	Төслөөр, багаар ажиллах
2.10	Усны үйлчилгээний салбар зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах боломжийг судлах;	ҮТА	2019-2021	Багаар ажиллах
2.11	Салбарын зах зээлийн загварууд, олон улсын хөгжлийн чиг хандлагын судалгаа хийх;	ҮТА	2019-2021	Багаар ажиллах
2.12	Усны үйлчилгээний салбарын нөхцөлд тохирсон зах зээлийн загварыг судалгааны үндсэн боловсруулж, хэрэгжүүлэх боломжийг судлах;	ҮТА	2019-2022	Багаар ажиллах
2.13	Салбарын зах зээлд оролцогч талуудын үйл ажиллагааны зарчим, дүрэм, журмыг боловсруулж хэрэгжүүлэх;	ҮТА	2020-2022	Багаар ажиллах
2.14	УХАТ-ын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, өөрчлөх үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцлийг боловсруулж, хэрэгжүүлэх	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
2.15	ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүнд суурилсан зохицуулалтын механизмыг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	ТЗА	2019-2022	Багаар ажиллах



№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
2.16	ТЗЭ-дийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн цахим санг хөгжүүлж, ашиглах, ил тод нээлттэй байдлыг хангах;	ЭЗМЗА, ТЗА, УТА	2019-2022	Төслөөр, /Багаар ажиллах
2.17	ТЗЭ-дийн үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагааг уялдуулан тооцдог аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх;	ТЗА, УТА	2019-2022	Багаар ажиллах
2.18	Бороо, хөрсний усыг төвлөрсөн шугамд нийлүүлэхэд төлбөр тооцдог гадаад орны жишгийг судлах;	УТА	2019-2021	Багаар ажиллах
2.19	Төвлөрсөн шугамд нийлүүлж байгаа бороо, хөрсний ус зайлуулах, төлбөр тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх;	ЭЗМЗА, ТЗА, УТА	2019-2022	Төслийн ажил
2.20	Нөөц (санхүү, хүний нөөц, материаллаг) үр дүнтэй хуваарилж, зарцуулах жишиг загвар боловсруулах;	УТА, ТЗА	2019-2022	Багаар ажиллах
2.21	Хөрөнгө оруулалтыг татах цэвэр бохир усны үйлчилгээний бодит өртгийг тодорхойлж, тарифын шинэчлэлтийг үе шаттай хэрэгжүүлэх;	УТА	2019-2022	Багаар ажиллах
2.22	Салбарын санхүү бүртгэлийн нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх;	УТА, ЭЗМЗА	2019-2021	Багаар ажиллах
2.23	Үр дүнд суурилсан зохицуулалтыг хийх менежментийн арга барилыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	ЭЗМЗА	2019-2022	Багаар ажиллах

**Стратегийн 3 дугаар зорилго: Хангагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
3.1	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэнд хяналт, шалгалтыг хийх	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
3.2	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэнд хяналт, шалгалтыг хийх	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
3.3	Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулж, зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
3.4	Хяналт, шалгалтын журам, аргачлал, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх	ТЗА, УТА	2019-2022	Багаар ажиллах
3.5	ТЗЭ-ийн үйл ажиллагаанд тухай бүр нь үнэлгээ өгч, ангилах, мэдээллийн санг бүрдүүлэх	ТЗА, УТА	2019-2022	Багаар ажиллах
3.6	ТЗЭ-чдийн үйл ажиллагааг найдвартай, тасралтгүй явуулах	ТЗА, УТА	2019-2022	Багаар ажиллах

	зорилгоор хяналт, шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх			
3.7	Хяналт, шалгалтын хүрээг өргөжүүлэх, чанаржуулах зорилгоор бэлтгэл ажлыг хангахад зориулагдсан төсвийг боловсруулж, хэрэгжүүлэх	ТЗА,УТА	2019-2022	Багаар ажиллах
3.8	Хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх, сургалт зохион байгуулахад шаардлагатай зардлыг төсөвлөж, хэрэгжүүлэх	ТЗА,УТА	2019-2022	Багаар ажиллах

**Стратегийн 4 дүгээр зорилго: Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
4.1	Сумдын УХАТ-ын байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах арга зүйн зөвлөгөө боловсруулах	ТЗА, УТА, ЭЗМЗА	2019-2022	Багаар ажиллах
4.2	Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулах, усны чанарт тавих хяналтыг дээшлүүлэх	ТЗА,ЭЗМЗА	2019-2022	Багаар ажиллах
4.3	Зөөврийн ус хангамжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	ТЗА,	2019-2022	Төслийн ажил/ Багаар ажиллах
4.4	Сайжруулсан АЦБ-ын тоог нэмэгдүүлэх	ТЗА	2019-2022	Төслийн ажил/ багаар
4.5	Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
4.6	Бага, дунд оврын АЦБ-ын туршилт тохируулгыг жигдрүүлэх, байгальд нийлүүлэх бохир усны стандартыг сайжруулах	ТЗА	2019-2022	Багаар ажиллах
4.7	Усны зүй зохистой хэрэглээ, хэмнэлтийн арга механизмыг нэвтрүүлэх замаар салбарын усны бодит алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх	ТЗА	2019-2022	Өдөр тутмын ажил
4.8	Баталгаат ундны ус, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын судалгааг гаргаж, мэдээллийн санд төвлөрүүлэх	ТЗА, УТА,ЭЗМЗА,	2019-2022	Төслийн ажил/ Багаар ажиллах

**Стратегийн 5 дугаар зорилго: Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн байгууллага болох**

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж (Зорилгын лидер)	Хугацаа	Ажиллах хэлбэр
5.1	Зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг тогтмолжуулж хэрэгжүүлэх	ЭЗМЗА	2019	Өдөр тутмын ажил

5.2	Иргэд аж ахуйн нэгж байгууллагыг цаг үеэ олсон, хүртээмжтэй мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	ЭЗМЗА	2019-2021	Өдөр тутмын ажил
5.3	Хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хангасан бодлого, зохицуулалтыг боловсруулж, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих	ЭЗМЗА, ТЗА, УТА	2019-2020	Багаар ажиллах
5.4	Салбарын хөгжлийг дэмжсэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	ЭЗМЗА, ТЗА, УТА	2019-2022	Багаар ажиллах
5.5	Гадаад болон өөрийн орны зохицуулалтын байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтарсан үйл ажиллагаа, ажил хэргийн түншлэлийг бий болгох	ЭЗМЗА, ТЗА, УТА	2019-2022	Төслийн ажил/ Багаар ажиллах
5.6	Усны үйлчилгээний чиглэлийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх	ЭЗМЗА, ТЗА, УТА	2019-2022	Өдөр тутмын ажил
5.7	Санхүүгийн бүртгэл, тооцооны үйл ажиллагааг стандартын дагуу хэрэгжүүлэх, хэвшүүлэх	ЭЗМЗА	2019-2020	Өдөр тутмын ажил
5.8	Мэдлэг чадварт суурилсан хүний нөөцийн сонгон шалгаруулалтын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх	ЭЗМЗА	2019-2020	Багаар ажиллах
5.9	Ажлын гүйцэтгэл, мэдлэг чадварт суурилсан цалин урамшууллын тогтолцоог боловсруулж нэвтрүүлэх	ЭЗМЗА	2019-2020	Багаар ажиллах
5.10	Хүний нөөцийн сургалт, хөгжлийн хэрэгцээнд тулгуурласан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ЭЗМЗА	2019-2021	Багаар ажиллах